



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/183

Хэрлэн сум

Үнэлгээ хийхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн оролцоот Нэг Хэнтий арга хэмжээний хүрээнд иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор khentii.mn сайтын сумд цэсэн дэх 18 сум 4 тосгоны ил тод байдлыг улирал бүр үнэлж, үнэлгээний тайланг сум, тосгон бүрээр гаргаж хяналт тавих ажлын зардалд 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын Иргэдийн оролцоот Нэг Хэнтий арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА  Д.АЮУРБУНЬ



